



САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 49,А/118

Улаанбаатар хот

ТӨЛБӨРИЙН ЖИШИГ ХЭМЖЭЭ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.5 дахь хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"- г нэгдүгээр, "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт ил тод байршуулан иргэдийг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын цахим бүртгэл болон санхүүгийн програмд зохих өөрчлөлт хийж хоорондын уялдааг нь сайжруулах арга хэмжээ авахыг төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаалаар батлагдсан төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээг мөрдөж эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээг холбогдох журмын дагуу санхүүжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Л.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлсэн төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлэх орлогыг жил бүрийн төсөвт хянаж тусгахыг Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Буянтогтох), Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.
5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай" Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 264/А/293 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД

Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх нэмэлт үйлчилгээний жагсаалт

№	Тусламж, үйлчилгээний төрөл	Тусламж, үйлчилгээний ерөнхий жагсаалт	Тусламж, үйлчилгээний нэр төрөл	Код	Төлбөрийн жишиг хэмжээ
867	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл, мэрэгчгүйтэл, шавжгүйтгэл /м2/	31401001	450
868	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат хоол	31401002	5000-15000
869	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	ЭМБ-ын тусгай хог хаягдал цуглуулах устгах (кг)	31401003	20,000
870	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (люкс)	31401004	30000-60000
871	Нэмэлт үйлчилгээ	Нэмэлт үйлчилгээ	Эмнэлгийн төлбөртэй өрөөний үйлчилгээ (хагас люкс)	31401005	10000-30000
872	Нэмэлт үйлчилгээ	Шарил хадгалах үйлчилгээ	Шарил хадгалах үйлчилгээ (нэг хоногт, эмнэлгийн нас баралтаас бусад тохиолдолд)	31402001	28,000
873	Нэмэлт үйлчилгээ	Шарил тээвэрлэх үйлчилгээ	Шарил тээвэрлэх үйлчилгээ (1 км-т, яаралтай болон түргэн тусламжаас бусад тохиолдолд)	31402002	3,000
874	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат ариутгал	Бикс, боодол (том, дунд, жижиг)	31404001	15,000
875	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат ариутгал	Дезкамер (матрас, гудас, хөнжил, дэр, гадар даавуу), ширхэгээр	31404002	4,500
876	Нэмэлт үйлчилгээ	Захиалгат угаалга	дотуур хувцас, ширхэгээр	31405001	4,000